

“Амгалан дулааны станц” ТӨХК – ийн эзэмшил /баланс/ - ийн дагнасан Хэрэглээний салбар замд УБТЗ ХНН-ийн сэлгээний зүтгүүрээр вагон тавьж өгөх, татаж авах тухай гэрээний сунгалтын НЭМЭЛТ ГЭРЭЭ

УБТЗ ХНН

ХУУЛЬ ЗҮЙН АГ БА

18 MAR 2022

ГЭРЭЭНИЙ БҮРТГЭЛ

№

ТТГ/21/249-1 34/2022

2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн ТТГ/21/249 дугаартай “Амгалан дулааны станц” ТӨХК – ийн эзэмшил /баланс/ - ийн дагнасан Хэрэглээний салбар замд УБТЗ ХНН-ийн сэлгээний зүтгүүрээр вагон тавьж өгөх, татаж авах тухай гэрээ - ний 10.4-р заалтад заасны дагуу талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр дараах нөхцөлөөр гэрээг сунгаж байна.

1. Гэрээний 10.2 дах заалтанд заасан гэрээний хугацааг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэхээр сунгав.

2. Төмөр замын тээврийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам, зааварт өөрчлөлт орсон, шинэчилэгдэн батлагдсан зэргээс шалтгаалж УБТЗ ХНН-ийн гэрээний батлагдсан загварт өөрчлөлт орсон тохиолдолд өөрчлөгдсөн зүйл, заалтаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.

3. Эзэмшигчийн улсын бүртгэлийн гэрчилгээ, төмөр замын тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хугацаа эсвэл салбар зам ашиглалт буюу арчлалтын гэрээ энэхүү гэрээний хүчинтэй хугацаанаас өмнө дуусгавар болсон, цуцлагдсан тохиолдолд энэхүү гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа тухайн гэрчилгээ, зөвшөөрөл эсвэл салбар зам ашиглалт, арчлалтын гэрээний хугацаа дуусгавар болсон буюу цуцлагдсан өдрөөс эхлэн дуусгавар болно.

4. Үндсэн гэрээнд хавсаргасан аливаа бичиг баримт, баримт материал, өөрчлөгдөөгүй, хүчин төгөлдөр болохыг талууд хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд өөрчлөлтийг мэдэгдээгүй, нуун дарагдуулснаас шалтгаалж гэрээний нэг талд хохирол учирвал нөгөө тал үл маргах журмаар хохирлыг төлж барагдуулна.

5. Гэрээнд дараахь материалыг хавсаргах бөгөөд энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

- Үндсэн гэрээ ба түүний 1.2.1 дахь заалтад заасан бичиг баримт, баримт материал өөрчлөгдөөгүй, хүчин төгөлдөр болохыг баталсан болон гэрээг сунгахыг хүссэн эзэмшигч талын албан бичиг

- Улсын бүртгэлийн гэрчилгээ

- Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектын гэрчилгээ

- Зам ашиглалт болон зам арчлалтын гэрээ, төлбөр төлсөн баримт

- Гэрээ дүгнэсэн акт

- Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах эрх бүхий этгээдийг нотолсон баримт /итгэмжлэл, компанийн дүрэм гэх мэт/

Эзэмшигчийг төлөөлж

УБТЗ-ыг төлөөлж

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцтай гэрээ бөгөөд мэдээлэл тус өөр бусад этгээдэд хувааж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлэхгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу харилцлага хүлээлгэх болно.

6. Үндсэн гэрээний бусад заалтыг урьдын адил хүчин төгөлдөрт тооцох бөгөөд талууд дагаж мөрдөх үүрэгтэй.

7. Энэхүү гэрээний нэмэлт нь Монгол хэл дээр 2 эх хувь байх бөгөөд хоёр талын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, УБТЗ-ын Хууль зүйн албанд дугаар авч, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн ТТГ/21/249 дугаартай "Амгалан дулааны станц" ТӨХК – ийн эзэмшил /баланс/ - ийн дагнасан Хэрэглээний салбар замд УБТЗ ХНН-ийн сэлгээний зүтгүүрээр вагон тавьж өгөх, татаж авах тухай гэрээ -ний салшгүй хэсэг болно.

ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ ЗААЛТТАЙ ТАНИЛЦАЖ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН
БӨГӨӨД ЯМАР НЭГЭН МАРГААНГҮЙ БОЛОХЫГ БАТЛАВ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

УБТЗ ХНН-ийг төлөөлж:
ТЭЭВЭРЛЭЛТ, ХӨДӨЛГӨӨН
ХАРИУЦСАН ЗАМЫН

ОРЛОГЧ ДАРГА


/Д.АМАРБАЯСГАЛАН/

Д

НЮ

ДС

Эзэмшигчийг төлөөлж:
"Амгалан дулааны станц" ТӨХК-ийн



/Ш.БАЯНМӨНХ/

Тэргүүн дэд бөгөөд ерөнхий инженер

/М.ЦОГТСАЙХАН/

Инженерийн хэсгийн Ахлах инженер

/Б.БАТЦООЖ/

Эзэмшигчийг төлөөлж:

УБТЗ-ыг төлөөлж:

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцар хамгаалах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

Эзэмшигчийг төлөөлж

УБТЗ-ыг төлөөлж

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцар хамгаалах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.